ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖИЛД "ТӨВ АЙМГИЙН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ" СУДАЛГАА 2017 ОН

## Гарчиг


**I. Өмнөх үг.**

**II. Улсын хэмжээний нийгэм эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эзлэх зиндаа**

**III. Засаг захиргааны нэгж, Дотоодын нийт бүтээгдэхүүн**

**IV. Хүн ам**

IV.1. Суурин хүн ам, Өрхийн тоо.

IV.2. Бүтэн, Хагас өнчин хүүхдийн тоо.

IV.3. 16 хүртлэх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй болон,Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо

IV.4. 16 хүртэлх насны хүүхэдтэй гэр бүлгүй эмэгтэйчүүд, Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн тоо.

IV.5. 1000 хүнд ногдох төрөлт, нас баралт.

IV.6. Төрөлт, нас баралт, гэрлэлт, гэр бүл цуцлалт,үрчлэлт болон хүн амын дундаж наслалт

IV.7. Эдийн засгийн идэвхитэй хүн ам, Ажиллагчдын тоо.

IV.8. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, Ажилгүйдлийн түвшин.

**V. Малын тоо,бүтэц**

V.1. Нийт малын болон Тэмээний тоо.

V.2. Адуу,Үхрийн тоо.

V.3. Хонь, Ямааны тоо.

**VI. Газар,тариалан**

VI.1. Тариалсан талбай, Хураан авсан үр тариа.

VI.2. Хураан авсан Төмс, Хүнсний ногоо.

**VII. Төсөв**

VII.1. Орон нутгийн төсвийн орлого, Зарлага.

VII.2. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлсэн орлого.

**VIII. Аж үйлдвэр, Барилга**

VIII.1. Аж үйлдэврийн бүтээгдэхүүн борлуулалт, Гадаад дотоодын хамтарсан барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт,их засварын ажил.

**IX. Боловсрол, Соёл, Эрүүл мэнд**

IX.1. Ерөнхий боловсролын сургуулийн тоо, ЕБС-д өдрөөр суралцагсад.

IX.2. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын тоо,ЕБС-ийн нэг багшид ногдох суралцагчид

IX.3.Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага. Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолт, үзэгчид.

IX.4. Музейн үзвэр, үзэгчид, Сүм хийдийн тоо.

IX.5. Их эмчийн болон нэг их эмчид ногдох хүний тоо.

IX.6. Нэг сувилагчид ногдох хүн, Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн өвчтний тоо.

IX.7. Үр хөндөлт, Халдварт өвчнөөр өвчлөөд бүртгэгдсэн хүмүүс.

IX.8. 1000 амьд төрсөн хүүхдэд ногдох Нялхсын эндэгдэл, Төрөхийн улмаас эндсэн эхийн тоо

**X. Гэмт хэрэг**

X.1. Бүртгэгдсэн гэмт хэргийн болон Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо.

# Өмнөх үг

2017 оны жилийн эцсийн байдлаар Төв аймаг улсын хэмжээний газар нутгийн 4.73%, засаг захиргааны (нийт сумдын) нэгжийн 7.96%, нийт хүн амын 3.0%, Өрхийн 3.4%, эдийн засгийн идэвхитэй хүн амын 3.7%, нийт ажиллагсадын 3.9%, нийт малын 7.1%, үүний дотор тэмээний 0.8%, адууны 9.5%, үхрийн 7.1%, хонины 8.2%, ямааны 5.6%, тариалсан талбайн 20.8 хувь, хураан авсан үр тарианы 4.4 хувь, төмсний 34.2 хувь, хүнсний ногооны 3.9 хувь нь ногдож, Дотоодын нийт бүтээгдэхүүний 1.8 хувийг үйлдвэрлэж, орон нутгийн төсвийн орлогын 2.9 хувийг бүрдүүлж, зарлагын 3.1 хувийг зарцуулав. Улсын хэмжээний Ерөнхий боловсролын сургуулийн 3.9%, тэнд суралцагсадын 2.6 %, СӨБ-ийн 3.5 хувь үйл ажиллагаа явуулав.

1000 хүнд ногдох төрөлт улсын дунджаас 1.3 промилоор доогуур, 1000 хүнд ногдох на баралт улсын дунджаас 0.7 промилоор дээгүүр, хүн амын дундаж наслалт улсын дундажаас 2.96 насаар илүү гарлаа.

Аймгийн дүнгээр амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдэл 10.0 байгаа нь улсын дунджаас 3.6 промилоор бага юм.

Ажилгүйдлийн түвшин улсын дунджаас 5.6 нэгжээр бага, нэг их эмчид ногдох хүний тоо улсын дунджаас 137 хүнээр, нэг сувилагчид ногдох хүн 58 хүнээр тус тус их байгаа нь тухайн мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангамжтай холбоотой .

х . х . х

2017 онд Улсын хэмжээнд манай аймаг сумын тоогоор I, багийн тоогоор VI, газар нутгийн хэмжээгээр XII, хүн амын тоогоор VIII, малын тоогоор IV, газар тариалангийн үйлдвэрлэлээрээ II, Дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээр VI, хүн амын дундаж наслалтаараа V, эдийн засгийн идэвхитэй хүн амын тоогоор IV, ажиллагсадын тоогоороо III, бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоогоороо XXI, орон нутгийн орлого бүрдүүлэлтээр VI, зарлага хэрэглээгээрээ VI, Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтаараа X, барилга угсралт, их засварын ажлаар VIII, Ерөнхий боловсролын сургуулийн тоогоор V, сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын тоогоороо I байрт байгаа бол, Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын тоогоор XII, цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоогоор VII, нэг их эмчид ногдох хүний тоогоор IX, нэг сувилагчид ногдох хүний тоогоор VIII байр тус бүр эзлэв.

Тайлбар: Энэ зэрэгцүүлэлт судалгааг ҮСХ-оос гаргадаг Монгол улсын статистикийн 2011-2017 оны эмхтгэл болон жил бүрийн бюллетень танилцуулга, статистик мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn сайтыг ашиглав.

Статистикийн хэлтсийн

дарга Ж.Отгончулуун.

# Товч танилцуулга

Төв аймаг 1921 оноос өмнөх халх 4 аймгийн нэг болох Түшээтхаан аймагт харьяалагдаж байв. Ардын Засгийн газрын гишүүдийн 1923 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 38 дугаар тогтоолоор аймаг, хошуудыг хаад, ноёдын нэрээр нэрлэж байсныг уулын нэрээр нэрлэхээр шийдвэрлэснээр Богдхаан уулын аймаг одоогийн Төв, Сэлэнгэ, Дундговь, аймаг бүхлээрээ өмнөговь аймгийн зүүн хэсэг, Дорноговь аймгийн баруун хагас, Булган аймгийн зүүн урд хагас, Архангай, Өвөрхангай аймгийн зүүн хэсгийг хамарсан Монгол улсын хойд хилээс өмнөд хил хүртэл хангай, говийг хосолсон өргөн уудам нутагтай, засаг захиргааны том нэгж байжээ. 1923 онд Төв аймгийг байгуулжээ.

Төв аймаг 74.0 мянган хавтгай дөрвөлжин киломерт газар нутагтай, нутаг дэвсгэрийн 81.1 хувийг бэлчээр, 15.4 хувийг ой мод эзэлдэг. Улс орныхоо эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээгээрээ тэргүүлэх үүрэгтэй аймгуудын нэгд манай аймаг зүй ёсоор ордог. Аймгийн хөгжлийн төдийгүй стратегийн чухал салбар нь хүнс, хөдөө аж ахуйн салбар бөгөөд аймгийн ДНБ-ий 43.6 орчим хувийг үйлдвэрлэдэг.

Манай аймаг Улаанбаатар хотын зах зээлд ойр,зам дэд бүтэц харьцангуй хөгжиж байгаа, хөдөө аж ахуйн гол бүс нутаг болдог онцлогтой.

х х х

Төв аймгийн ДНБ 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 490.0 тэрбум төгрөгт хүрч улсын нийт ДНБ-ий 1.8 хувийг үйлдвэрлэсэн ба 2012 оноос 76.1%, 2013 оноос 30.8%, 2014 оноос 3.3%-өөр тус тус өсч, 2015 оноос 9.7%, 2016 оноос 4.0 хувиар тус тус буурав. ДНБ-ийг эдийн засгийн салбараар ангилбал 43.6 хувийг ХАА-н салбар, 31.8 хувийг аж үйлдвэр барилгын салбар, 24.6 хувийг үйлчилгээний салбар үйлдвэрлэжээ. Үүнийг улсын дүнтэй харьцуулбал ХАА салбар 33.0 пунктээр дээгүүр, аж үйлдвэр, барилгын салбар 7.6 пунктээр, үйлчилгээний салбар 25.4 пунктээр тус тус доогуур байна.

Суурин хүн амын тоо 2017 онд 2016 оныхоос 1.6 мянгаар, 2015 оныхоос 4.7 мянгаар, 2011 оныхоос 10.1 мянгаар тус тус өсч 94.5 мянга болов. Нийт 30.0 мянган өрх байгаа нь улсын нийт өрхийн 3.4 хувийг эзлэв.

Аймгийн хэмжээнд бүтэн өнчин 90 хүүхэд, хагас өнчин 1021 хүүхэд бүртгэгдлээ. Өнчин хүүхдийн тоо жил ирэх тусам аажмаар буурсаар 2011 онтой харьцуулахад бүтэн өнчин 29.1 хувь, хагас өнчин 4.0 хувиар буурлаа.

18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 1321 болж 2011 оноос 96.0 хувиар, 2012 оноос 1.1 дахин, 2013 оноос 26.8 хувиар, 2014 оноос 54.5 хувиар, 2015 оноос 26.9 хувиар, 2016 оноос 17.7 хувиар өсөв. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн улсын дүнд эзлэх хувь 2.5 хувь буюу өмнөх оныхоос 0.6 пунктээр өсөв. 18 хүртлэх насны хүүхэдтэй гэр бүлгүй эмэгтэйчүүдийн улсын дүнд эзлэх хувь 0.2 пунктээр, төрсөн эхчүүдийн тоо 0.1 пунктээр тус тус өсөв. Аймгийн дүнгээр 1000 хүнд ногдох төрөлт улсын дунджаас 1.3 промилээр бага, нас баралт 0.7 промилээр их гарлаа.

2017 онд Төв аймагт 2094 хүүхэд мэндэлж, 577 хүн нас баран цэвэр өсөлт 1517 болов. 472 хос гэрлэлтээ бүртгүүлж, 74 хос гэрлэлтээ цуцлуулжээ. Төрсөн хүүхдүүдийн 1062 нь хүү, 1032 нь охин төрж төрөх үеийн хүйсийн харьцаа 102.9 байлаа. Хүн амын дундаж наслалт жил бүр аажмаар өсч 2017 онд 72.85 хүрснээр улсын дунджаас 2.96 насаар дээгүүр боллоо.

Эдийн засгийн идэвхитэй хүн ам 50.3 мянга байгаагийн 48.6 мянга нь ажиллагчид юм. Ажилгүйдлийн түвшин 3.2 хувьд хүрсэн ба 2011 онд 5.5, 2012 онд 5.9, 2013 онд 8.4, 2014 онд 6.2, 2015 онд 4.4, 2016 онд 2.7 хувь байв.

Малын тоо 2016 оноос 0.4 хувиар буурч 4685.1 мянга хүрсэн ба тэмээ 3.5 мянга, адуу 375.6 мянга, үхэр 310.8 мянга, хонь 2461.1 мянга, ямаа 1534.2 мянга тоологдлоо. 2017 оны улсын нийт малын 7.1 хувь Төв аймагт тооллогдлоо. Нийт малын тоо болон төрлөөр аймгуудыг байр

эзлүүлбэл Төв аймаг нийт малын тоогоор IV, адуугаар II, үхрээр IV, хониор IV, ямаагаар IX, тэмээгээр XIV байранд орлоо.

2017 онд 108,8 мянган га-д тариалалт хийж үр тариа 10.5 мянган тн, төмс 41.7 мянган тн, хүнсний ногоо 3.2 мянган тоннийг хураасан нь 2016 оныхоос үр тариа 87.7%, хүнсний ногоо 60.5%,төмс 35.5 хувиар тус тус буурлаа.

Төв аймаг 2017 онд төсвийн орлогын 2.9 хувийг бүрдүүлж, зарлагын 3.1 хувийг зарцуулав. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгодог санхүүгийн дэмжлэгээс 2014 онд 10.2 тэрбум.₮, 2015 онд 9.4 тэрбум.₮, 2016 онд 8.8 тэрбум.₮, 2017 онд 8.8 тэрбум төгрөгийн дэмжлэг тус тус авчээ.

Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалт оны үнээр 2017 онд 47.5 тэрбум төгрөг болж өмнөх оноос 13.9 хувиар өсөв. Төв аймгийн борлуулалт улсын нийт борлуулалтын 0.3 хувийг эзэлж 2011 оныхтой адил, 2012 оныхоос 0.23 пунктээр, 2013 оныхоос 0.17 пунктээр өссөн бол, 2014 оныхоос 0.07 пунктээр, 2015 оныхоос 0.06 пунктээр, 2016 оныхоос 0.07 пунктээр тус тус буурчээ.

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 2011 оныхоос 2.5 дахин, 2012 оныхоос 3.5 дахин, 2013 оныхоос 1.3 дахин, 2014 оныхоос 42.1%, 2015 оныхоос 11.8%-аар тус тус буурч, 2016 оныхоос 11.8 хувиар өсч 2017 онд 29.2 тэрбум төгрөг болов. Аймгийн гүйцэтгэл улсын дүнд 1.0 хувийг эзэлжээ.

Ерөнхий боловсролын 31 сургууль /ЕБС/ үйл ажиллагаа явуулж өдрөөр суралцагчдийн тоо 14.8 мянга болов. Энэ нь өмнөх оноос 2.8 хувь өссөн үзүүлэлт юм. ЕБС-ын багш нарын тоо 763, нэг багшид ногдох суралцагчийн тоо 19.4 болж улсын дунджаас 0.6 хүүхдээр их гарлаа. 2017 онд 49 цэцэрлэг үйл ажиллагаа хэвийн явуулж, эдгээр цэцэрлэгт 7533 хүүхэд хамрагдлаа. Аймгийн мэргэжлийн урлагийн байгууллага 26 удаагийн тоглолтоор 16.7 мянган үзэгчдэд үйлчлэв. Музейн сан хөмрөг 2017 онд өмнөх оноос 27 үзмэрээр нэмэгдсэн ба 28.4 мянган үзэгч хүлээн авлаа.

Төв аймагт 2017 онд буддын 4 сүм хийд үйл ажиллагаа явуулж тэдгээрт 30 хүн ажиллажээ. Сүм хийдийн тоо өмнөх оноос 1-ээр, ажиллагчдын тоо 4-өөр тус тус өсөв.

Аймгийн хэмжээнд 2017 онд 218 их эмч ажиллаж, нэг их эмчид 430 хүн ногдсон нь улсын дунджаас 137 хүнээр илүү байгаа нь их эмчийн хүрэлцээ тааруу байгааг харууллаа. Мөн нэг сувилагчид 317 хүн ногдлоо. Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүний тоо 2011 онтой адил, 2012 оноос 0.2 мянган хүнээр өсч, 2013 оноос 0.5 мянган хүнээр, 2014 оноос 0.4 мянган хүнээр буурсан бол 2015 оноос 1.0 мянган хүнээр өсч 2016 оноос 1.0 мянган хүнээр буурaн 15.6 мянга болжээ. Үр хөндөлтийн тоо Төв аймагт 2011 оноос хойш нилээн хэлбэлзэж 2017 онд 62 болон улсын дүнгийн 0.4 хувийг эзлэв. Халдварт өвчнөөр өвчилж бүртгэгдсэн хүний тоо өмнөх оноос 33.4% хувь буюу 403 хүнээр буурав.

Нялхасын эндэгдэл 1000 амьд төрсөн хүүхэд тутамд 10.0 байгаа нь улсын дунджаас 3.6 промилоор, өмнөх оноос 10.5 промилоор бага байв. 2015, 2016 онд төрөхийн улмаас тус бүр 1 эх эндэж байсан бол 2017 онд төрөхийн улмаас эх эндээгүй.

2017 онд аймгийн хэмжээнд 810 гэмт хэрэг бүртгэгдэж 380 хүн шүүхээр ял шийтгүүлжээ. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 2011 оноос 139-өөр, 2012 оноос 38-аар тус тус өсч, 2013 оноос 112-оор, 2014 оноос 149-өөр, 2015 оноос 53-аар, 2016 оноос 2 гэмт хэргээр тус тус буурав. Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо 2014 оноос хойш тогтмол өсч 2014 онтой харьцуулахад 1.1 дахин, 2015 оноос 52.0%, 2016 оноос 30.6%-аар тус тус өсөв. Улсын дүнд аймгийн эзлэх хувь 2017 онд бүртгэгдсэн гэмт хэрэг 2.5 хувь, шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо 4.2 хувь болов. 2017 онд 18-с дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо тус аймагт 130 байгаа нь өмнөх оноос 4-өөр буурч, тухайн оны улсын дунджаас 29 хүнээр бага гарлаа.

## Улсын хэмжээний нийгэм эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн зэрэгцүүлэлтэнд эзлэх зиндаа

| | Сум дүүргийн тоогоор | | | | | Багийн тоогоор | | | | | Нутаг дэвсгэрийн хэмжээ (мян.кв.км) | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 |
| **Төв Tov** | 1 | 1 | 1 | 1 | **1** | 6 | 6 | 6 | 6 | **6** | 12 | 12 | 12 | 12 | **12** |
| **Улсын дүн *** | **339** | **339** | **339** | **339** | **339** | **1592** | **1602** | **1613** | **1613** | **1615** | **1564.9** | **1564.9** | **1564.1** | **1564.1** | **1564.1** |

| | Хүн амын нягтшил (1 км-т ногдох хүн ) | | | | | Хүн амын тоо (мян-хүн) | | | | | Малын тоогоор (сая-тол) | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
| А | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 |
| **Төв Tov** | 10 | 10 | 11 | 11 | **10** | 8 | 8 | 8 | 8 | **8** | 3 | 2 | 2 | 4 | **4** |
| **Улсын дүн *** | **1.9** | **1.9** | **2.0** | **2.0** | **2.0** | **2870.9** | **2937.9** | **2990.2** | **3063.6** | **3131.8** | **45.1** | **51.9** | **56.0** | **61.5** | **66.2** |

| | Дотоодын нийт бүтээгдэхүүн ( оны- үнээр) (их наяд ₮) | | | | | Барилга угсралт, их засварын ажил (их наяд -₮ ) | | | | | Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт (их наяд-₮) | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
| А | 31 | 32 | 33 | 34 | 35 | 36 | 37 | 38 | 39 | 40 | 41 | 42 | 43 | 44 | 45 |
| **Төв Tov** | 4 | 5 | 4 | 4 | **6** | 16 | 7 | 13 | 9 | **8** | 7 | 6 | 9 | **10** | **11** |
| **Улсын дүн *** | **17.6** | **21.9** | **23.2** | **23.9** | **27.2** | **1.7** | **2.4** | **2.3** | **2.9** | **2.9** | **6.5** | **11.1** | **10.0** | **11.1** | **15.2** |

| | **Хураасан** (мян-тн) | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үр тариа бүгд | | | | | төмс бүгд | | | | | хүнсний ногоо бүгд | | | | |
| | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
| А | 46 | 47 | 48 | 49 | 50 | 51 | 52 | 53 | 54 | 55 | 56 | 57 | 58 | 59 | 60 |
| **Төв Tov** | 2 | 2 | 2 | 2 | **2** | 1 | 1 | 1 | 1 | **1** | 4 | 4 | 3 | 4 | **4** |
| **Улсын дүн *** | **387.0** | **518.8** | **216.3** | **483.5** | **238.1** | **191.6** | **161.5** | **163.8** | **165.3** | **121.8** | **101.8** | **104.8** | **72.3** | **94.4** | **82.1** |

### Засаг захиргааны нэгж. 2017 оны байдлаар.
### ADMINISTRATIVE UNITS

| | Сум дүүр- Number of soums and districts | Баг хороо-ны тоо Number of bags and khoroos | Нутаг дэвс-гэрийн хэмжээ мян.кв.км Territory thous kb.km | Хүн амын нягтшил Population density |
|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 |
| **- Төв Tov** | **27** | **97** | **74.0** | **1.3** |
| **Улсын дүн Total** | **339** | **1765** | **1564.1** | **2.0** |

### Дотоодын нийт бүтээгдэхүүний хувь хэмжээ,оны үнээр
### GROSS DOMESTIC PRODUCT, by aimag, at current prices

( тэр бум-₮, mln. tog )

| | Бүгд , Total | | | | | | 2017 оны дүнд эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ү ү н э э с | | |
| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017* | Х.А.А Agricul-ture | А.Ү,Барилга Industry,con struction | Үйлчилгээ Services |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **- Төв Tov** | **278.3** | **374.5** | **474.5** | **542.6** | **510.6** | **490.0** | **43.6** | **31.8** | **24.6** |
| **Улсын дүн Total** | **16688.4** | **19174.2** | **22227.1** | **23150.4** | **23942.9** | **27167.0** | **10.6** | **39.4** | **50.0** |



## Суурин хүн амын тоо, улс, аймгаар, оны эцэст.
## RESIDENT POPULATION,by aimag and total ,at the end ot the year

(мян-хүн thous.persons)

| | Суурин хүн амын тоо resident population | | | | | | | 2017% 2011 | 2017% 2016 | Улсын дүнд аймгийн эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | | | 2011 | 2016 | 2017 |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| **- Төв** | **84.4** | **85.5** | **84.6** | **90.0** | **89.8** | **92.9** | **94.5** | **112.0** | **101.7** | **3.1** | **3.0** | **3.0** |
| **Улсын дүн** | **2704.5** | **2760.6** | **2823.1** | **2937.9** | **2990.2** | **3063.6** | **3131.7** | **115.8** | **102.2** | **100.0** | **100.0** | **100.0** |

## Өрхийн тоо, улс, аймгаар, оны эцэст.
## NUMBER OF HOUSEHOLDS, by aimag and total, at the end ot the year

(мян-өрх thous.households)

| | Өрхийн тоо households | | | | | | | 2017% 2011 | 2017% 2016 | Улсын дүнд аймгийн эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | | | 2011 | 2016 | 2017 |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| **- Төв** | **26.9** | **26.8** | **27.3** | **28.0** | **28.6** | **29.2** | **30.0** | **111.5** | **102.7** | **3.5** | **3.4** | **3.4** |
| **Улсын дүн** | **759.9** | **768.3** | **794.1** | **823.4** | **859.1** | **869.8** | **885.6** | **116.5** | **101.8** | **100.0** | **100.0** | **100.0** |



## Бүтэн өнчин хүүхдийн тоо улс, аймгийн хэмжээнд
## NUMBER OF ORPHAN CHILDREN,by aimag and total

| | Бүтэн өнчин хүүхдийн тоо | | | | | | | 2017% 2011 | 2017% 2016 | Улсын дүнд аймгийн эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | | | 2011 | 2016 | 2017 |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| **- Төв** | **127** | **123** | **109** | **128** | **113** | **86** | **90** | **70.9** | **104.7** | **3.0** | **2.4** | **2.7** |
| **Улсын дүнд** | **4305** | **4288** | **4096** | **3984** | **3856** | **3552** | **3383** | **78.6** | **95.2** | **100.0** | **100.0** | **100.0** |

## Хагас өнчин хүүхдийн тоо улс, аймгийн хэмжээнд
## NUMBER OF SINGLE PARENT CHILDREN,by aimag and total

| | Хагас өнчин хүүхдийн тоо | | | | | | | 2017% 2011 | 2017% 2016 | Улсын дүнд аймгийн эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | | | 2011 | 2016 | 2017 |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| **- Төв** | **1063** | **1042** | **1018** | **997** | **1026** | **1004** | **1021** | **96.0** | **101.7** | **2.9** | **3.0** | **3.1** |
| **Улсын дүнд** | **36465** | **36143** | **35461** | **35053** | **34060** | **33680** | **33319** | **91.4** | **98.9** | **100.0** | **100.0** | **100.0** |

## 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо, аймгаар.
## NUMBER OF HOUSEHOLDS WITH 4 AND MORE CHILDREN AGED BELOW 16, by aimag and total

| | 18 хүртлэх насны 4 түүнээс дээш хүүхэдтэй өрх | | | | | | | 2017% 2011 | 2017% 2016 | Улсын дүнд аймгийн эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011* | 2012* | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | | | 2011* | 2016 | 2017 |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| **- Төв** | **674** | **619** | **1042** | **855** | **1041** | **1122** | **1321** | **196.0** | **117.7** | **2.8** | **3.1** | **3.7** |
| **Улсын дүн** | **24078** | **23502** | **37413** | **40327** | **36122** | **36681** | **36190** | **150.3** | **98.7** | **100.0** | **100.0** | **100.0** |

*Тайлбар * 16 хүртлэх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрх*

*Note * Household with 4 and more children aged below 16 years old*

## Өрх толгойлсон эх, аймгаар.
## MOTHERS WHO HEAD HOUSEHOLDS, by aimag and total

| | Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо | | | | | | | 2017% 2011 | 2017% 2016 | Улсын дүнд аймгийн эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | | | 2011 | 2016 | 2017 |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| **- Төв** | **2723** | **2632** | **2348** | **2166** | **2544** | **2104** | **1954** | **71.8** | **92.9** | **3.4** | **2.7** | **2.5** |
| **Улсын дүн** | **81013** | **81557** | **81741** | **80838** | **78606** | **77717** | **76893** | **94.9** | **98.9** | **100.0** | **100.0** | **100.0** |

## 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх, аймгаар.
## MOTHERS WHO HEAD HOUSEHOLD WITH CHILDREN AGED BELOW 18 YEARS OLD, by aimag and total

| | Хүүхэдтэй гэр бүлгүй эмэгтэйчүүдийн тоо | | | | | | | 2017% 2011 | 2017% 2016 | Улсын дүнд аймгийн эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011* | 2012* | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | | | 2011 | 2016 | 2017 |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| **- Төв** | **1174** | **1255** | **1110** | **1070** | **1136** | **1061** | **1129** | **96.2** | **106.4** | **3.0** | **2.8** | **3.0** |
| **Улсын дүн** | **38709** | **38559** | **39904** | **40433** | **39320** | **38147** | **38148** | **98.6** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |

*Тайлбар * 16 хүртлэх насны хүүхэдтэй гэр бүлгүй эмэгтэйчүүд*

*Note * Single women with children aged bellow 16 years old*

## Төрсөн эхчүүдийн тоо, аймаг, улсаар
## NUMBER OF WOMEN WHO GIVE BIRTHS,by aimag and total

| | Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн тоо | | | | | | | 2017% 2011 | 2017% 2016 | Улсын дүнд аймгийн эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011* | 2012* | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | | | 2011 | 2016 | 2017 |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| **- Төв** | **2171** | **2126** | **2352** | **2230** | **1279** | **2144** | **2192** | **101.0** | **102.2** | **3.1** | **2.8** | **2.9** |
| **Улсын дүн** | **69155** | **72568** | **78784** | **79965** | **80434** | **77757** | **74476** | **107.7** | **95.8** | **100.0** | **100.0** | **100.0** |

## 1000 хүнд ногдох хүн амын төрөлт улс, аймгаар,
## LIVE BIRTHS PER 1000 POPULATION, by aimag and total

| | 1000 хүнд ногдох төрөлт (тоогоор ) | | | | | | | Аймаг улсын зөрүү +, - | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2011 | 2016 | 2017 |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 10 | 11 | 12 |
| **- Төв** | **25.6** | **25.9** | **14.4** | **26.5** | **14.2** | **23.9** | **22.6** | **0.5** | **-2.0** | **-1.3** |
| **Улсын дүн** | **25.1** | **26.0** | **27.5** | **28.0** | **27.1** | **25.9** | **23.9** | **x** | **x** | **x** |

## 1000 хүнд ногдох хүн амын нас баралт улс, аймгаар, оны эцэст.
## DEATHS PER 1000 POPULATION, by aimags and total

| | 1000 хүнд ногдох нас баралт (тоогоор) | | | | | | | Аймаг улсын зөрүү +, - | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2011 | 2016 | 2017 |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 10 | 11 | 12 |
| **- Төв** | **8.0** | **5.8** | **6.6** | **4.4** | **6.8** | **6.8** | **6.2** | **1.1** | **1.0** | **0.7** |
| **Улсын дүн** | **6.9** | **6.3** | **5.9** | **5.6** | **5.8** | **5.8** | **5.5** | **x** | **x** | **x** |

## Төрсөн, нас барсан, гэрлэсэн, гэр бүл цуцалсан хүний тоо, үрчлэгдсэн хүүхдийн тоо, улс, аймгаар 2017 он.
## NUMBER OF BIRTHS, DEATHS, MARRIAGES, DIVORCES AND ADOPTION, by aimag and total, in the 2017

| | Төр-сөн* хүүхэд Births* | Нас бар-сан хүн Deaths | Цэвэр өсөлт Natural increase | Гэрлэл-тийн тоо Marria-ges | Цуцал-сан хүн-ий тоо Divor-ces | Үрчлэг-дсэн хүүхэд Adop-tion | Төрсөн хүүхэд хүйсээр by sex | | Төрөх үеийн хүйсийн харьцаа sex ratio |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Эрэг-тэй male | Эмэг-тэй temale | |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **- Төв** | **2094** | **577** | **1517** | **472** | **74** | **26** | **1062** | **1032** | **102.9** |
| **Улсын дүн** | **75321** | **17357** | **57964** | **20470** | **3945** | **1739** | **38958** | **36363** | **107.1** |
| **Улсын дүнд эзлэх %** | **2.8** | **3.3** | **x** | **2.3** | **1.9** | **1.5** | **2.7** | **2.8** | **x** |

## Хүн амын дундаж наслалт, улс, аймгаар

| | Дундаж наслалт (тоо) Life Expectancy at birth. (number) | | | | | | | 2017% 2011 | 2017% 2016 | Аймгийн улсын дүнд харьцсан зөрүү +,- | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | | | 2016 | 2017 |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| **- Төв** | **70.28** | **71.04** | **71.46** | **72.06** | **72.61** | **72.93** | **72.85** | **103.66** | **99.89** | **3.36** | **2.96** |
| **Улсын дүн** | **68.32** | **68.71** | **69.11** | **69.57** | **69.89** | **69.57** | **69.89** | **102.30** | **100.46** | **x** | **x** |

## Эдийн засгийн идэвхитэй хүн ам, улс, аймгаар
## ECONOMICALLY ACTIVE POPULATION by aimag and total

(мян-хүн thous.persons )

| | Эдийн засгийн идэвхитэй хүн ам | | | | | | | 2017% 2011 | 2017% 2016 | Улсын дүнд эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | | | 2011 | 2016 | 2017 |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| **- Төв** | **47.9** | **46.9** | **45.1** | **44.0** | **47.3** | **49.0** | **50.3** | **105.0** | **102.7** | **4.3** | **3.8** | **3.7** |
| **Улсын дүн** | **1124.7** | **1151.1** | **1198.3** | **1206.6** | **1243.9** | **1275.6** | **1357.4** | **120.7** | **106.4** | **100.0** | **100.0** | **100.0** |

## Ажиллагчдын тоо, улс, аймгаар
## EMPLOYED by aimag and total

(мян-хүн thous.persons)

| | Ажиллагчдын тоо | | | | | | | 2017% 2011 | 2017% 2016 | Улсын дүнд эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | | | 2011 | 2016 | 2017 |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| **- Төв** | **45.3** | **44.2** | **41.3** | **41.2** | **45.1** | **47.7** | **48.6** | **107.3** | **101.9** | **4.4** | **4.2** | **3.9** |
| **Улсын дүн** | **1037.7** | **1056.4** | **1103.6** | **1110.7** | **1151.2** | **1147.8** | **1238.3** | **119.3** | **107.9** | **19.6** | **17.0** | **16.9** |

## Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо улс, аймгаар
## REGISTERED UNEMPLOYMENT by aimag and total

(хүнээр- person)

| | Бүртгэлтэй ажилгүйчүүд бүгд Unemployed - total | | | | | | | 2017% 2011 | 2017% 2016 | Улсын дүнд эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | | | 2011 | 2016 | 2017 |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| **- Төв** | **854** | **1040** | **1308** | **437** | **545** | **640** | **298** | **34.9** | **46.6** | **1.5** | **1.9** | **1.2** |
| **Улсын дүн** | **57171** | **35776** | **42772** | **36970** | **32788** | **34412** | **25450** | **44.5** | **74.0** | **100.0** | **100.0** | **100.0** |

## Ажилгүйдлийн түвшин улс, аймгаар
## UNEMPLOYMENT RATE by aimag and total

хувиар -percentage

| | Бүгд Total | | | | | | | 2017% 2011 | 2017% 2016 | Улс аймгийн зөрүү +, - | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | | | 2011 | 2016 | 2017 |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| **- Төв** | **5.5** | **5.9** | **8.4** | **6.2** | **4.4** | **2.7** | **3.2** | **54.2** | **118.5** | **2.2** | **7.3** | **5.6** |
| **Улсын дүн** | **7.7** | **8.2** | **7.9** | **7.9** | **7.5** | **10.0** | **8.8** | **107.3** | **88.0** | **x** | **x** | **x** |






**Малын тоо, улс, аймаг, төрлөөр оны эцэст**
**NUMBER OF LIVESTOCK, by type of livestock, by aimag**

| | Бүх малын тоо бүгд - Total мян - тол . thous.heads | | | | | | | 2017% 2011 | 2017% 2016 | Улсын дүнд аймгийн эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | | | 2011 | 2016 | 2017 |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| **- Төв** | **2962.0** | **3244.7** | **3573.0** | **4181.5** | **4458.6** | **4705.9** | **4685.1** | **158.2** | **99.6** | **8.2** | **7.6** | **7.1** |
| **Улсын дүн** | **36335.8** | **40920.9** | **45144.3** | **51982.6** | **55979.8** | **61549.2** | **66219.0** | **182.2** | **107.6** | **100.0** | **100.0** | **100.0** |

